



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 4/80

Улаанбаатар хот

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан  
сэргийлэх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль (шинэчилсэн найруулга) хүчин төгөлдөр үйлчилж гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хамрах хүрээ, зохицуулалт, чиглэл өөрчлөгдсөн тул Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний харьяа салбар, нэгжүүдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөөг хуулийн хүрээнд өөрийн байгууллагын онцлогт нийцүүлэн боловсруулан баталж, хэрэгжүүлж ажиллахыг Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын газар (П.Ариунболд)-д, Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д, салбар, нэгжийн дарга нарт тус тус даалгасгай.

2. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн “Салбар хороо шинэчлэн байгуулах тухай” А/128 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.МӨНХНАСАН